



ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 22 өдөр

Дугаар 5/46

Жаргалтхаан сум

С.Мөнхсаруулыг монгол хэл,
уран зохиолын багшаар томилох тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.4, Дотоод журмын 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтууд, Засгийн газрын 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Саранцэцэгийн Мөнхсаруулыг монгол хэл, уран зохиолын багшаар 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Багшийн ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүргийг хэрэгжүүлж, идэвх санаачлагатай ажиллахыг багш С.Мөнхсаруулд, ТҮБД-4 дүгээр шатлал, 1484000 (нэг сая дөрвөн зуун наян дөрвөн мянга) төгрөгөөр тооцон цалинжуулж, хууль тогтоомжоор олгогдсон бусад нэмэгдлийг олгохыг нягтлан бодогч (Г.Урансүх)-д, үйл ажиллагаанд хяналт тавьж, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг сургалтын менежер (Д.Бямбадорж)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Д.ЧИНБАТ

D/Tushaal-2025
232501092